



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/8

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогод ашиглах ном гарын авлага, тоног төхөөрөмжийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:

Ц.Шинэхүү

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга

Гишүүд:

Б.Мөнхбаатар

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Л.Нарантуяа

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Т.Мөнхбаяр

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Мэдээлэл, технологийн албаны мэргэжилтэн

Г.Төрмөнх

Ногоон соёл иргэншил хөгжил сан тэргүүн

Р.Дуламжав

“Нийгмийн хөгжлийн ертөнц” НҮТББ тэргүүн

Нарийн бичгийн дарга:

Г.Нямдаваа

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо /Ц.Шинэхүү/-д даалгасугай.


132003030

ТӨБЗГ тушаал-/2022

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг /Г.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

A red rectangular official stamp is located in the center of the page. The stamp contains Mongolian text, including the words "Урьдчилсан" (Preliminary) and "Төлөвлөгөө" (Plan). A large, stylized black handwritten signature is written over the stamp and extends to the right, crossing the name "Б.ЦЭНГЭЛ".